

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар: 01

Улаанбаатар хот

**Гэрээний загварт өөрчлөлт
оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.6, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 473 дугаар тогтоолоор малын хорогдлын босго үзүүлэлтийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Малын индексжүүлсэн даатгалын гэрээний загвар”-ын 2.8 дахь хэсгийн “2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 219” гэснийг “2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 473” гэж, 2.8.1 дэх заалтын “Архангай, Баян-Өлгий, Булган, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Орхон” гэснийг “Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл” гэж, 2.8.2 дахь заалтын “Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Увс, Дархан-Уул, Говьсүмбэр” гэснийг “Баянхонгор, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Увс, Хэнтий” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, “Малын индексжүүлсэн гэрээний загвар”-т орсон өөрчлөлтийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхланта)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг Засгийн газрын 2023 оны 473 дугаар тогтоол мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ